



"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 20/02

Чойбалсан хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60, 67, 71, 76 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Адуунчулуун" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Адуунчулуун" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, "Адуунчулуун" ХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

- A. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны зорилт
- B. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, 2020 оны эдийн засгийн төлөвлөлт
- C. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан
- D. Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашиг хувиарлахгүй талаарх ТУЗ-ийн шийдвэр, ашгийн тухай танилцуулга
- E. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох /кумулятив аргаар/

Хоёр. Хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, диллерийн компаниудад мэдэгдэх хугацааг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн хугацааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тогтоосугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга, загварыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын 02 дугаар хавсралтаар баталж Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонинд 2020 оны 03 дугаар сарын 13 -ны өдөр тус тус нийтлүүлэхийн зэрэгцээ давтан зарыг 03 дугаар сарын 30-нд өдөр тутмын /өдрийн сонин, зууны мэдээ/ болон орон нутгийн сонин /Дөл, Дорнод/ радио, телевиз /Мижиг, ТВ6, Дорнод ТВ/-д тус тус мэдээлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг холбогдох эрх бүхий албан тушаалтнуудад хариуцуулсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой, хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Баттогтох овогтой Шатар /ТУЗ-ийн дарга/-ыг томилж, тооллогын комисс болон зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 04 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Долоо. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурлыг бэлтгэл сайтай явуулахыг хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Гангамөрөн нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР

"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС



Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар: ХЗ-ийн бүртгэлийн дугаар

Санал өгөх хувьцааны тоо: Кумулятив саналын тоо:

"Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 20 -ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны зорилт			
2	Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, 2020 оны эдийн засгийн төлөвлөлт			
3	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тайлан			
4	Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хуваарлахгүй талаарх ТУЗ-ийн шийдвэр, ашгийн тухай танилцуулга			
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/		
	Ердийн гишүүд:			
1				
2				
3				
4				
5				
6				
7				
	Хараат бус гишүүд:			
1				
2				
3				
4				

Хувьцаа эзэмшигч.....Гарын үсэг.....

2020 оны сар өдөр

Саналын хуудас бөглөх санамж

- 1-4 дугаарт санал өгөхдөө санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг (-) гаж тэмдэглэнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
- Зөсөөрлөсөн болон бэллөсөн, давхардсан, залруулагатай санал өгөх хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтын кумулятив аргаар хурална. Кумулятив аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тооноос сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: тав 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг арав тус компанийн 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн хараат бус гишүүн байдлаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна үү. Хувьцаа эзэмшигч та саналын тооноос давсан санал өгөхгүйг анхаарна үү.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

Тооллогын комиссын дарга:

Тооллогын комиссын гишүүн:



"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 20 - ны өдрийн 14 цаг 00 минутад Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн хурлын танхимд болох тул хувьцаа эзэмшигчид та бүхэн хүрэлцэн ирнэ үү.

Бүртгэлийн өдөр: 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны зорилт
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, 2020 оны эдийн засгийн төлөвлөлт
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тайлан
4. Компанийн 2018 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2019 оны ногдол ашгийг хувиарлахгүй талаарх ТУЗ-ийн шийдвэр, ашгийн тухай танилцуулга
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд биечлэн ирж танилцах, мөн компанийн вебсайт www.aduunchuluun.mn болон и-мэйл хаяг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас лавлах боломжтой.

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9:00 – 16:00 цагийн хооронд ажиллана.

Имэйл: munu@aduunchuluu.mn

Утас: 88062945

**"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 16:00 цагийн хосронд "Адуунчулуун" ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ ирж танилцана уу.

Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт
4. Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Тооллогын комиссын дарга: Ж.Мөнхсайхан /Авто-ашиглалтын механик/

Тооллогын комиссын гишүүд:
М.Мөнхбаяр /ХММЗ-ын Механик/
Э.Баяржаргал /Компьютерийн инженер/
Ү.Ариунбат /ШТМ-ын нярав/
Б.Алтанцэцэг /Цалингийн нягтлан бодогч/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга: Ш.Баясгалан /Гүйцэтгэх захирал/

Зохион байгуулах комиссын гишүүд:
О.Гангамөрөн /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/
Б.Лайжийханд /Тосцооны нягтлан бодогч/
Б.Тэнгис /Эдийн засагч/
Д.Амаржаргал /БОХАА-н менежер/